



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай


Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.4, 28 дугаар зүйлийн 28.1.5, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийслэл хотод “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Зам тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Ажлын хэсгийн ахлагч Х.Нямбаатарт даалгасугай.

ДАРГА



С. АМАРСАЙХАН

Улсын онцгой комиссын даргын
2021 оны 07 дүгээр сарын 07 ны өдрийн
07 дугаар тушаалын хавсралт

БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД НИЙСЛЭЛ ХОТОД “ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ”

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 104 дүгээр тогтоолоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд нийслэлийн замын хөдөлгөөнд оролцох иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгоход энэ журмыг баримтална.

Хоёр. Зөвшөөрөл олгох

2.1. Улсын Онцгой комиссоос байгуулсан Ажлын хэсэг зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөл нь давтагдашгүй дугаар бүхий код /QR/ байна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан Ажлын хэсэг үйл ажиллагаанд нь хязгаарлалт тогтоогоогүй байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор хүсэлтийн дагуу зөвшөөрлийг олгоно.

2.3. Нийслэлийн нутаг дэвсгэрээс орон нутгийн чиглэлд зорчих иргэнд тухайн аймгийн онцгой комиссын зөвшөөрснөөр уул уурхай, газар тариалан зэрэг салбарын иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч, нэг удаагийн зөвшөөрлийг олгоно.

2.4. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын алба хаагч зайлшгүй шаардлагаар албаны чиг үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд тухайн салбарын сайд, эсхүл нийслэл, дүүрэг, хороодын Засаг даргын хүсэлтийг үндэслэж, тухай бүрт нь зөвшөөрлийг олгоно.

2.5. Эрүүл мэндийн яаралтай тусламж, оршуулгын үйл ажиллагаа, давагдашгүй хүчин зүйлээс үүссэн нөхцөл байдлын улмаас иргэн тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох бол цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч тухай бүр шийдвэрлэнэ.

2.6. Энэ журмын 2.3, 2.4-д заасан этгээд хүсэлтийг QR@gov.mn цахим хаягт илгээнэ.

2.7. Энэ журмын 2.6-д заасан хүсэлтийн хамт зөвшөөрөл авах үндэслэл, шалтгаан, хөдөлгөөнд оролцох хугацаа, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хуулбар, ажилтан, албан хаагчдын регистрийн дугаарыг ирүүлнэ.

2.8. Энэ журмын 2.1-д заасан Ажлын хэсэг QR@gov.mn цахим хаягт ирүүлсэн хүсэлтийг хянаж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

2.9. Иргэн, байгууллага системд бүртгэгдэж, олгосон зөвшөөрлийг www.smartcar.mn цахим хуудаснаас хэвлэн авч, тээврийн хэрэгслийн урд салхины шилний баруун доор жолоочийн харагдах байдалд нөлөөлөхгүйгээр байрлуулан ажлын үнэмлэхээ үзүүлж хөдөлгөөнд оролцоно.

2.10. Зөвшөөрлийг үнэ төлбөргүй олгох бөгөөд зөвшөөрлийг бусдад худалдах, ашиглуулах, хэвлэж олшруулах, тараах, зөвшөөрөгдсөнөөс бусад чиглэлээр ашиглах, цагийн хуваарийг зөрчиж хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

Гурав. Зөвшөөрлийг хүчингүй болгох

3.1. Дараах тохиолдолд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно:

3.1.1. зөвшөөрлийг хүчингүй болгох талаар зөвшөөрөл эзэмшигчээс хүсэлт гаргасан;

3.1.2. зөвшөөрнөөс бусад тээврийн хэрэгсэлд байрлуулж ашигласан;

3.1.3. зөвшөөрлийг өөр зориулалтаар ашигласан;

3.1.4. замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөгдсөн цагийг зөрчсөн;

3.1.5. зөвшөөрлийг бусдад худалдсан, хуурамч материал бүрдүүлж авсан;

3.1.6. зөвшөөрөл олгогдсон тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлсэн.

Дөрөв. Бусад

4.1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаанд нь хязгаарлалт тогтоогоогүй чиглэлийн байгууллагын тээврийн хэрэгслийн өмнө нь олгож байсан зөвшөөрлийг хүсэлт шаардахгүйгээр сэргээн олгох эсэхийг ажлын хэсэг шийдвэрлэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу зөвшөөрөл сэргээгдээгүй бол зөвшөөрөл олгогдоогүйд тооцно.

4.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын алба хаагч зайлшгүй шаардлагаар албаны чиг үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд ажлын үнэмлэхээ үзүүлж, цагийн хуваарийн дагуу нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж болно.